



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/676

Ховд

┌ Хуулийн хэрэгжилтийг хангах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 17 дугаар зүйлийн 17.3, 42 дугаар зүйлийн 42.1.1, 42.1.6, 43 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 111 дүгээр тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” журмыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг дарга, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт дараахь заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосугай.

1.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгох, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдын 25 хүн тутамд 1 хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэн ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд тухайн байгууллагын ажиллагчдын дундаж цалингийн 60 хувиар төлбөр төлөх

1.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд ээлтэй дэд бүтцийг бий болгох, орох, гарах гарц, ариун цэврийн өрөө, сургалт, үйлчилгээний танхим, коридорыг стандартад нийцүүлэх

1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх хөтөч ажилтныг томилж ажиллуулах, дохионы хэлний сургалт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцах арга зүйд сургах, олон нийтэд чиглэсэн томоохон үйл ажиллагааг дохионы хэлний орчуулгатай хүргэх

1.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дараалал харгалзахгүй үйлчилгээ үзүүлэх, хэнийг ч орхигдуулахгүй үйлчилгээний ээлтэй орчин бий болгох, мэдээллийг хүн бүрт тэгш хүртээмжтэй хүргэх

1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлж, төсвийн хөрөнгөөр хийх худалдан авалтад тэргүүн ээлжинд хамруулах,

1.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд тулгуурлан хамруулан хөгжүүлэх, уралдаан тэмцээн, соёл, урлагийн арга хэмжээнд оролцох, өөрийн авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

2.Боловсрол соёл урлагийн газар, бүх шатны боловсролын байгууллагын захирал, эрхлэгч нарт дараах заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосугай.


2.1 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” журмыг хэрэгжүүлэх ажлын бэлтгэлийг хангаж , зохион байгуулах

2.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суралцахад таатай орчин, хариуцлагыг бий болгож, хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах, багшийн урамшууллын асуудлыг судлан шийдвэрлэх

2.3 Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүд, иргэдэд амьдрах ухаань болон мэргэжлийн чиг баримжаа олгох насан туршийн боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

3. Захирамжинд тусгагдсан заалтуудыг сум болон салбарын байгууллагуудын ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулахыг Хяналт –шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс /Б.Гомбосүрэн/-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Б.Даваадорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ